



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД 2019 ОНЫ 3-Р УЛИРЛЫН
БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ/

2019.10.04

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ хийх зорилго нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэгдсэн арга хэмжээний гүйцэтгэлийн явцын талаар дүгнэлт гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгсний үндсэн дээр төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх зохион байгуулалт, зохицуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Эрх зүйн үндэслэл нь “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоол, “Ажил хариуцуулж, хэрэгжүүлэх тухай” Зам, тээврийн хөгжлийн яамны ТНБД-ын 2017 оны 59 дүгээр тушаал болно. Эдгээр тогтоол, тушаалын заалтын дагуу хэрэгжүүлсэн ажлын явцад хийсэн хяналт-шинжилгээний тайлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба энэ нь Засгийн газраас тус яамны үйл ажиллагааг үнэлж дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болохын зэрэгцээ яамны ерөнхий менежер, нэгжийн менежерүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийн түвшинг үнэлж, дүгнэх нэг үзүүлэлт болох ач холбогдолтой.

Арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн түвшингийн хувийг тогтоохдоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг баримталсан болно.

Хоёр. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн байдал

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн сайдын “үндсэн хэрэгжүүлэгч байгууллага” буюу дангаар болон толгойлон хэрэгжүүлэх 117 арга хэмжээн дээр “МТЗ” ТӨХК-ийн толгойлон хэрэгжүүлэх 5, “УБТЗ” ХНН-ийн толгойлон хэрэгжүүлэх 3, Концесс эзэмшигч “Нортерн рейлвейс” ХХК-ийн толгойлон хэрэгжүүлэх 1 арга хэмжээг нэмж, нийт 126, бусад байгууллага, Засгийн газрын гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх 20, оролцон хэрэгжүүлэх 1 арга хэмжээ, нийт 147 арга хэмжээ тусгагдсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын үндсэн хэрэгжүүлэх нийт 126 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж дуусгах хугацаагаар нь ангилж үзүүлбэл:

Хүснэгт 1

2016 -2020	2017 он	2018 он	2019 он	2020 он
	2.107.14, 2.107.15, 2.107.32, 2.109.2, 2.114.7, 2.114.8, 2.114.9, 2.114.14, 2.114.16, 2.116.2,	2.107.1, 2.107.4, 2.107.13, 2.107.16, 2.107.18, 2.107.23, 2.107.33, 2.108.1, 2.111.1, 2.113.3, 2.114.5, 2.114.15, 2.115.4, 2.118.3, 2.118.4, 6.3.1.1, 6.8.2.2, 6.9.1.1, 6.9.1.2, 6.9.1.3,	2.107.5, 2.107.6, 2.107.7, 2.107.24, 2.107.27, 2.107.28, 2.107.30, 2.113.2, 2.114.13, 2.119.3, 2.119.4, 3.2.33.6, 6.11.1.1, 6.13.1.1, 6.14.2.2, 6.16.1.4, 6.21.1.1	2.11.2, 2.107.2, 2.107.3, 2.107.8, 2.107.9, 2.107.10, 2.107.11, 2.107.12, 2.107.17, 2.107.19, 2.107.20, 2.107.21, 2.107.22, 2.107.25, 2.107.26, 2.107.29, 2.107.31, 2.107.34, 2.107.35, 2.108.2, 2.109.1, 2.110.1, 2.111.2, 2.111.3, 2.111.4, 2.112.1, 2.113.1, 2.114.1, 2.114.2, 2.114.3, 2.114.4, 2.114.6, 2.114.10, 2.114.11, 2.114.12, 2.114.17, 2.115.1, 2.115.2, 2.115.3, 2.116.1, 2.117.1, 2.117.2, 2.117.3, 2.117.4, 2.118.1,



	2.118.6, 6.2.1.1,	6.9.1.4, 6.16.1.1, 6.16.1.2, 6.16.1.3, 6.19.1.1, 6.19.2.2, 6.19.3.3,		2.118.2, 2.118.5, 2.118.7, 2.119.1, 2.119.2, 2.120.1, 2.121.1, 2.121.2, 2.121.3, 2.121.4, 3.2.33.7, 4.1.3.6, 4.4.5.2, 5.1.3.1, 5.6.1.5, 5.6.1.6, 5.6.5.2, 6.1.1.1, 6.4.1.1, 6.7.1.1, 6.8.1.1, 6.14.1.1, 6.16.1.5, 6.16.1.6, 6.16.1.7,
126	12	27	17	70

Үүнээс Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 онд үндсэн хэрэгжүүлэх 121 арга хэмжээний биелэлтийг 3-р улирлын байдлаар үнэллээ. Хэрэгжилт **дунджаар 74.5%** хувьтай байна.


Төлөвлөгөөнд туссан арга хэмжээг яамны газар, хэлтэс, байгууллагын хариуцсан асуудал тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2

Үнэлгээ	БТГ	ТЗДТБХЗГ	АЗБХЗГ	АТБХЗГ	АТБХЗХ	"МТЗ" ТӨХК	"УБТЗ" ХНН	Концесс эзэмшигч "Нортерн рэйлвейс" ХХК	Далайн захиргаа	НИЙТ
100%	2.113.2, 2.114.16 2.118.7, 3.2.33.7,	2.111.1, 2.113.2, 2.118.1, 5.1.3.1, 5.6.1.5,	2.107.4, 2.107.7, 2.107.14, 2.107.16, 2.107.18, 2.107.19, 2.107.23, 2.107.32, 2.113.2, 2.121.4, 6.11.1.1, 6.19.2.2,	2.113.2, 2.116.2, 2.118.4, 5.1.3.1,	2.114.1, 2.114.3, 2.114.6, 2.114.8, 2.114.9, 2.114.14, 2.114.16, 2.114.17, 2.115.1, 2.115.4, 5.1.3.1,		2.111.1 2.118.1			
	4	5	12	4	11	-	2	-	-	29
70%	2.118.3, 5.1.3.1, 5.6.1.6, 5.6.5.1	2.111.2, 2.117.1, 2.117.2, 2.117.3, 5.6.1.6	2.107.1, 2.107.13, 2.107.15, 2.107.17, 2.119.4, 2.121.1, 2.121.2, 4.4.5.2, 5.1.3.1, 5.6.1.6, 6.3.1.1,	2.118.2, 2.120.1, 4.4.5.2, 5.6.1.6, 2.116.1,	2.114.2, 2.114.4, 2.114.5, 2.114.7, 2.115.2, 2.115.3,		2.111.2		2.117.1, 2.117.2, 2.117.3,	
	4	5	11	5	6	-	1	-	3	26
40%	2.113.1 2.113.3, 3.2.33.6, 4.1.3.1	2.111.3 2.113.1 2.113.3,	2.107.2, 2.107.5, 2.107.6, 2.107.28, 2.113.1, 2.113.3, 2.119.3, 6.14.2.2, 6.16.1.3, 6.16.1.7,	2.113.1, 2.113.3, 2.118.5, 2.118.6,	2.113.1, 2.113.3, 2.114.13,					
	4	3	10	4	3	1	-	-	-	16
0%	2.11.2,	2.108.1 2.112.1,			6.2.1.1,	2.108.1,		2.112.1		
	1	2	-	-	1	1	-	1	-	4
Үнэлэх боломжгүй		2.108.2, 2.109.1, 2.109.2, 2.110.1, 2.111.4, 2.117.4,	2.107.3, 2.107.8, 2.107.9, 2.107.20, 2.107.22, 2.107.24, 2.107.25, 2.107.26, 2.107.27, 2.107.30, 2.107.31, 2.107.33, 2.107.34, 2.107.35, 2.119.1, 2.119.2, 2.121.3, 6.1.1.1, 6.4.1.1, 6.7.1.1, 6.8.1.1, 6.8.2.2, 6.9.1.1, 6.9.1.2, 6.9.1.3, 6.9.1.4, 6.13.1.1, 6.14.1.1, 6.16.1.1, 6.16.1.2, 6.16.1.4, 6.16.1.5, 6.16.1.6, 6.19.1.1, 6.21.1.1		2.114.10 2.114.11, 2.114.12, 2.114.15, 6.19.3.3	2.108.2, 2.109.1, 2.109.2, 2.110.1,			2.117.4	
	-	6	35	-	5	3	-	-	1	46
Нийт	13	21	68	13	26	5	3	-	4	121
	64.6%	64.7%	71.8%	70%	78.1%	20%	81%	0	70%	71.5%


Нийт арга хэмжээний хэрэгжилтийг газар, хэлтэс, байгууллага тус бүрээр ангилж үзүүлбэл:

Зураг 1



Нийт арга хэмжээг хэрэгжилтийн хувиар үзүүлбэл:

Зураг 2



Засгийн газрын гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх 20 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж дуусгах хугацаагаар нь ангилж үзүүлбэл:

Хүснэгт 3

	2016 -2020	2017 он	2018 он	2019 он	2020 он
Хамтран хэрэгжүүлэх	20	2.95.1	2.85.3	2.85.4, 2.100.1	2.11.1, 2.113, 2.48.6, 2.48.7, 2.58.2, 2.65.2, 2.100.3, 2.119.5, 3.110.10, 3.2.33.5, 3.3.28.5, 3.3.29.1, 3.4.6.1, 3.4.6.2, 4.4.5.1, 5.6.1.4
		1	1	2	16
Оролцон хэрэгжүүлэх	1				3.2.28.4
		-	-	-	1

Засгийн газрын гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх 20 арга хэмжээний биелэлтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар үнэллээ. Хэрэгжилт дунджаар 73.5% хувьтай байна. Үүнд:

Хүснэгт 4

Хариуцах байгууллага	Нийт заалт	100	70	40	0	Үнэлэх боломжгүй	Хувь
ЗТХЯ	20	6	7	4	-	3	73.5%

Гурав. Дүгнэлт

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016-2018 онд үндсэн хэрэгжүүлэх 121 арга хэмжээний хэрэгжилтийн хувьд авч үзвэл 2019 оны 3 дугаар улирлын байдлаар үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 29, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 26, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 16, хэрэгжээгүй 4, үнэлэх боломжгүй 46 арга хэмжээ байна. Хэрэгжилт дунджаар 71.5% хувьтай байна

2. ЗГҮАХ-т аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан заалтуудын 14 арга хэмжээ тэргүүлэх зорилтуудад ЗТХС-ын хэрэгжүүлэх арга хэмжээтэй давхцсан байна.

3. Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 16, хэрэгжээгүй 4 арга хэмжээ нь нийт арга хэмжээний 16.5% эзэлж байна. Үнэлэх боломжгүй 46 арга хэмжээ буюу нийт арга хэмжээний 38% нь эзэлж байна.

Дараах шалтгааны улмаас 46 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үнэллээ. Үүнд:

- Авто замын чиглэлээр:

Авто замын барилга, засварын 26 арга хэмжээг улсын төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 2019 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй, 8 арга хэмжээг гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, 1 арга хэмжээ шүүхийн маргаантай;

- Төмөр замын чиглэлээр:

“Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах, төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээний ТЭЗҮ үр ашиг багатай гарсан;

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаас Оюутолгой чиглэлийн салбар төмөр зам нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын асуудлаас шалтгаалж барих эсэх нь тодорхойгүй;

“Шивээхүрэн-Сэхэ” боомтын төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх асуудал нь царигийн өргөний хэмжээг УИХ-аар тогтоогүй үед барилгын ажил эхлүүлэх боломжгүй тухай хөрөнгө оруулагч талаас албан ёсоор мэдэгдсэн;

“Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, суурь бүтэц барих ажлыг эхлүүлэх арга хэмжээг Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод тусгаагүй, царигийн хэмжээг тогтоогоогүй, төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрөл эзэмшигчийг шийдвэрлээгүй;

“Монгол-Зөвлөлтийн Хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай” 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх чиглэлээр хэлэлцээг үргэлжлүүлэх арга хэмжээ нь “УБТЗ”-ын санхүүгийн томоохон асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа энэ үед цаг хугацааны хувьд тохиромжгүй;

Үндэсний хөгжлийн газраас концессын гэрээгээр улсын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг Засгийн газарт оруулж хэлэлцүүлэн ач холбогдлоор нь эрэмблэсний дагуу Хөвсгөл нуурт усан замын төв зогсоолыг концессын гэрээгээр барих асуудал тус газрын төлөвлөгөөнд 2019 оны 4 дүгээр улиралд тусгагдаад байна.

- Агаарын тээврийн чиглэлээр:

Агаарын тээврийн салбарт Ховд, Дорнод, Өмнөговь, аймгуудын нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх 3 арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй;

Чингис Хаан ОУНБ-ын үйл ажиллагааг шинэ нисэх буудалд шилжүүлэх, шинэ нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулах арга хэмжээ нь Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг концессын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сарын дараа ашиглалтад оруулахаар хэлэлцээ хийгдсэн;

Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2019 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 40%-ийн, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 70%-ийн үнэлгээтэй дараах арга хэмжээнүүдийг жилийн эцсийн хүрэх түвшинд хүргэхийг Бодлого, төлөвлөлтийн газарт зөвлөж байна. Үүнд:

- “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх 2.11.2,

- Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах 2.113.1,

- Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа хийх, батлах, Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны байгууллагатай болох ажлыг эхлүүлэх 2.113.3,

- Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хариуцлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүн ам болон хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах судалгаа хийх 3.2.33.6,

- Зам, тээврийн салбарын статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн бүртгэлийн нэгдсэн систем бүрдүүлэх 2.118.3,

- Зам, тээврийн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан шинэчлэх, шинээр боловсруулах, дэд салбарын талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэх 5.1.3.1,

- БНХАУ-ын нутаг дэвсгэрээр далайд гарах, дамжин өнгөрөх, олон улсын зэрэглэл бүхий авто болон төмөр замын боомт нэмж байгуулах асуудлыг хамтран шийдвэрлэх 5.6.1.6,

- Гуравдагч улсаас БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин Монгол Улсад импортлогдож буй бараа, бүтээгдэхүүний тарифын болон тарифыг бус хориг саадыг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг шат дараалалтайгаар зохион байгуулах 5.6.5.1;

2. Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 40%-ийн, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 70%-ийн үнэлгээтэй дараах арга хэмжээнүүдийг жилийн эцсийн хүрэх түвшинд хүргэхийг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт зөвлөж байна. Үүнд:

- Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай авто замыг барих 2.107.2,

- Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замыг барих 2.107.5,

- Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн замтай холбох 120 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх 2.107.25,

- Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай авто замыг барих 2.107.28,

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Шар тээг-Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлж дуусгах /концесс/ 6.14.2.2

- Өгийнуур-Батцэнгэл-Их Тамир чиглэлийн 130.6 км хатуу хучилттай авто замыг барих 2.107.3,

- Дашинчилэн-Их тамир чиглэлийн 130 км авто замын Орхон голын 220 урт метр төмөр бетон гүүрийг барих 2.107.6,

- Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замаас Мандал сумын төв хүртэл 32 км хатуу хучилттай авто зам барих /аймаг, орон нутагт эрх шилжүүлсэн/ 6.16.1.3

- Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замд өргөтгөл, шинэчлэл хийх /БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр/ 2.119.3,

- Сумдын төвийн хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлэх 6.16.7.7,

- Ховд-Өлгий- Улаанбайшинт чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто замыг барих 2.107.1,

- Баянхонгор-Арвайхээр чиглэлийн огцом эргэлтийн 4.4 км трасс өөрчлөх 2.107.13,

- Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замыг барих 2.107.15,

- Тосонцэнгэлийн баруун талын 4 замын уулзвараас Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замыг барих 2.107.17,

- Туул гол дээгүүрх Баянзүрхийн 288 урт метр болон Сонсголонгийн 289.4 урт метр төмөр бетон гүүрийг барих 2.119.4,

- Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээний бэлэн байдлыг жилийн туршид хангах, арчлалт, засварын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгэх 2.121.1,

-Улаанбаатар-Дархан-Алтанбулаг, Улаанбаатар-Арвайхээр, Дархан-Эрдэнэт, Улаанбаатар-Чингис, Налайх-Чингис чиглэлийн нийт 504 км авто замд их засвар шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх 2.121.2;

3. Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 40%-ийн, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 70%-ийн үнэлгээтэй дараах арга хэмжээнүүдийг жилийн эцсийн хүрэх түвшинд хүргэхийг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, “Монголын төмөр зам” ТӨХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Далайн захиргаа” УТҮГ-т тус тус зөвлөж байна. Үүнд:

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг барих 2.108.1,

- Богдхан төмөр замын трассыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулан барилгын ажлыг эхлүүлэх 2.111.3,

- Улаанбаатар төмөр замын гол замын их засварын ажлыг гүйцэтгэх /200 км/ 2.11.2,

- Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх 2.117.1,
- Далбааны эзэн улсын үүрэг, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, Монголын хөлөг онгоцны бүртгэлийн чанарыг сайжруулах, өргөжүүлэх 2.117.2,
- Байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэхэд анхаарч төрийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэд хоорондын уялдаа холбоог сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх 2.117.3,
- Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан тээврийн салбарын төсөл, арга хэмжээг судалж хэрэгжүүлэх 2.116.1;

4. Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 40%-ийн, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 70%-ийн үнэлгээтэй дараах арга хэмжээнүүдийг жилийн эцсийн хүрэх түвшинд хүргэхийг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт зөвлөж байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх 2.118.5,
- Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах 2.118.6,
- Аюулгүй, найдвартай, их багтаамжийн нийтийн тээврийг хөгжүүлэн 400-аас доошгүй автобусаар парк шинэчлэх 2.118.2,
- Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх 2.120.1;

5. Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 40%-ийн, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 70%-ийн үнэлгээтэй дараах арга хэмжээнүүдийг жилийн эцсийн хүрэх түвшинд хүргэхийг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэст зөвлөж байна. Үүнд:

- Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах ЗС хүчин чадалтай болгох 2.114.13,
- Орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулахад агаарын тээврийн компаниудыг татварын бодлогоор дэмжих 2.114.2,
- Авиакомпаниудын бизнесийн тогтвортой ажиллагааг хангах, өртөг зардлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөн, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих 2.114.4,
- Иргэний нисэхийн салбарын бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх 2.114.5,
- Үндэсний агаарын тээвэрлэгчийн менежментийг концессоор гүйцэтгүүлэх замаар бүтэц, менежментийг шинэчлэх 2.114.7,
- Ерөнхий зориулалтын нисэхийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх 2.115.2,
- Ерөнхий зориулалтын нисэхэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих, бага оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хялбаршуулах 2.115.3;

6. Төмөр замын барилгын ажлыг хэрэгжүүлэх 4 арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг сайжруулж барилгын ажлыг гүйцэтгэх талаар ахиц гаргахыг Бодлого, төлөвлөлтийн газар, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, “Монголын төмөр зам” ТӨХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН, концесс эзэмшигч “Нортерн рейлвейс” ХХК-иудад;

7. Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй арга хэмжээнүүд дээр Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна бусад арга замаар хөрөнгө оруулалтыг шийдэх чиглэлээр санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Бодлого, төлөвлөлтийн газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хэлтсүүдэд тус тус зөвлөж байна.



Танилцсан:

Сайд	Б.Энх-Амгалан
Дэд сайд	Л.Халтар
Төрийн нарийн бичгийн дарга	С.Батболд
Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Болор-Эрдэнэ
Бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ж.Сэрээтэр
Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Х.Оргил-Эрдэнэ
Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Гантулга
Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Б.Артур
Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Мягмарсүрэн
Хянасан: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	М.Энхболд
Боловсруулсан: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн	Н.Буянт